

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит хурлын тэмдэглэл

2021.04.07

Улаанбаатар хот

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 07 - ны өдөр 15 цагт Сүхбаатар дүүрэг, Бага Тойрог, Пума Имperiал зочид буудлын хажууд байрлах УБ Гранд зочид буудлын хурлын 1603 тоот өрөөнд 15:00 эхлэв. Хурал цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан онлайн болон заалны хосолмол хэлбэрээр зохион байгуулагдсан. Хуралд онлайнаар оролцох зааврыг брокер дилерийн компаниудад имэйлээр хүргүүлж мөн компанийн вэбсайт дээр хэрхэн оролцох онлайнаар оролцох зааврыг байршуулсан.

/Өмнө төлөвлөсөн Пума Имperiал буудал хөл хорио гарсан тул хажуугын УБ Гранд зочид буудлын хурлын өрөөнд хурлыг зохион байгуулах шаардлагатай болсон. Учир нь Пума руу ирсэн хувьцаа эзэмшигчид олоход хялбар, мөн компанийн зүгээс нэг ажилтан буудлын гадаа хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг чиглүүлэхээр үлдээсэн./

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авав. Хурлын ирц 91 хувь буюу саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдээс 8,454,666 ширхэг хувьцааг эзэмшигчид оролцож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар томилогдсон Г.Оюунболд хуралд оролцох боломжгүй болсон тул хурлын даргаар ТУЗ-ын гишүүн Д. Батсайханыг хувьцаа эзэмшигчдийн 8,454,576 ширхэг хувьцаа буюу 91%-ын төлөөлөл сонгосон. Хурлын дарга Д. Батсайхан хурлыг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

1. Компанийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах
2. Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт батлах
3. Компанийн хэлбэр өөрчлөх буюу ХХК болгох асуудлыг хэлэлцэх
4. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай
5. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
6. Халаасны хувьцааг бичилтээс хасах тухай
7. Хөрөнгө худалдан борлуулах тухай
8. Их хэмжээний хэлцэлийг хэлэлцэх тухай /Морьт Импекс ХХК-тай хийсэн гэрээний сунгалт болон хөрөнгө оруулалтын гэрээний сунгалт/
9. ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, шинээр сонгох
10. 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсөв
11. Ногдол ашиг хувиарлахгүй тухай шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоол танилцуулах
12. Бусад

Хурлын дарга Д. Батсайхан

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан онлайнаар болон биеэр оролцох хосолсон хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж байна. Онлайнаар гадаад улс

орноос хувьцаа эзэмшигчид оролцож байгаа учраас хурлыг англи болон монгол хэл дээр явуулах нь зүйтэй. Хэлэлцэх асуудлыг гүйцэтгэх захирал О.Амартүвшин танилцуулна.

Гүйцэтгэх захирал О.Амартүвшин:

Одоогийн байдлаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчид дан гадны хувьцаа эзэмшигч байгаа тул англи хэл дээр эхлээд явуулъя. 2020 оны хувьд бидний хувьд мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаагаа өөрчлөн эхлүүлсэн. Үүний хүрээнд бид эхний ээлжинд аялал жуулчлалын оператор компани болон кампуудын захиалгын удирдлагын системийг хөгжүүлсэн. Мөн мэдээллийн технологийн шийдэл нэвтрүүлэх тендерүүдэд оролцсон. Одоо хөгжүүлж байгаа системийг танилцуулъя. */Системийн танилцуулга явагдав /* Мэдээлэл технологийн үйлчилгээг, систем хөгжүүлэхэд мэргэжлийн баг бүрдүүлэх шаардлага тулгарч байгаа. Хэд хэдэн удаагийн хөл хорио тогтоосон нь энэ үйл ажиллагаанд нөлөөлсөн.

Мөн 2020 онд хувьцаа эзэмшигчдийн зүгээс тавьсан санал болон өмнөх хурлын шийдвэрийн шаардах эрх хэрэгжүүлэх ажиллагааг авч хэрэгжүүлсэн. Энэ нь нэгж хувьцааг 300 төгрөгөөр эргүүлэн худалдаж үйл ажиллагаа зохион байгуулсан. Одоогийн байдлаар компани 4.4 сая гаран халаасны хувьцаатай байна. Олон улсад гарч эхлээд байсан Ковид-19 цар тахалтай холбоотой шаардах эрхээ хэрэгжүүлж чадаагүй, амжаагүй тул эргүүлж хувьцаагаа зарах хүсэлтэй байна гэдэг хүсэлтүүдийг удаа дараа хувьцаа эзэмшигчдийн зүгээс тавьсан. Цар тахлын нөхцөл байдлаас үүдэн түрээсийн үйл ажиллагаа алдагдалтай, хөрөнгө зарж борлуулах үйл ажиллагаа удаашралтай ч явагдаж байна. Өмчийг зарж борлуулах явцад олон жилийн өмнө худалдан авсан тайлангийн үнээр зарагдах боломжгүй байсан. Хувьцаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг санхүүжүүлэх үүднээс өмнөх хурлаар өөрийн үл хөдлөх хөрөнгийг борлуулах шийдвэр гарсан. Энэхүү нөхцөл байдал мөн үнэ ханшинд сөргөөр нөлөөлсөн.

Охин компанийн эзэмшлийн Өмнөговь аймгийн Цогт-Цэций суманд байдаг 2000м газрын хувьд компани эдийн засгийн өсөлтийн үед өндөр үнэтэй худалдан авч /120 гаран сая төгрөгийн хөрөнгө оруулалт орсон/ үйлчилгээний үл хөдлөх хөрөнгө барихаар төлөвлөж байсан байна, гэвч одоогийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан, анхны худалдан авсан үнийн дүнгийн 50%-ийн үнээр бид зарж борлуулахаар санал болгож буй хэдий ч борлуулагдаагүй байна.

Хэлэлцэх асуудлын нэг болон хоёрдугаар зүйл мөн 2020 оны санхүүгийн аудитлагдсан тайланг хүргүүлсэн байгаа билээ. Эдгээр дээр асуулт байвал авъя.

Хувьцаа эзэмшигч Маркус Сеиблэр

Хурлын материалыг англи хэл дээр хүлээж авсан, асуулт алга.

Хурлын дарга Д. Батсайхан

Асуулт байхгүй бол гуравдугаар асуудлыг танилцуулна уу.

Компанийн захирал О.Амартүвшин:

Гуравдугаар асуудлыг танилцуулъя, хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн хэлбэрийг өөрчлөн ХХК болгох санал тавьж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлт гаргасан. Үндсэн шалтгаан нь компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгөөс

багассан, түүнчлэн компанийн хөрөнгөд бүртгэлтэй 4.5 тэрбумын авлага нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан бэрхшээлтэй харагдаж байгаа. Энэхүү авлага нь Туул Сонгино Усны Нөөц төслийн санаачлагчтай байгуулсан гэрээн дээр үндэслэдэг бөгөөд 2009 оноос хойш сунгагдсаар ирсэн. Энэ хугацаанд компанийн зүгээс 0.7 тэрбум төгрөгийн зардлыг газрын татвар, харуул хамгаалалтанд зарцуулсан. Төслийн газрыг харуул хамгаалалтгүй орхих боломжгүй байдаг, учир нь талбайгаас дур мэдэн зөвшөөрөлгүй хайрга хулгайлах, газар хатгах, хог хаягдал асгах зэрэг эрсдэлтэй нөхцөл байдлууд үүсдэг. Мөн нийслэлийн газрын албанаас төслийн урд талбайг тусгай хэрэгцээнд орж байгаа мэдээлэл ирсэн. Энэ нь эзэмшлийн хугацаа дуусах үед нийслэлээс гэрчилгээг сунгахгүй. Одоогийн үйл ажиллагааны зардал өндөр тул багасгах шаардлагатай тул компанийн хэлбэрийг өөрчилж ХХК болгох асуудал танилцуулагдлаа.

Хурлын дарга Д. Батсайхан

Үүнээс өмнө сүүлд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид одоог хүртэл танилцуулсан асуудлаа монгол хэлээр танилцуулж саналыг нь сонсоно уу.

Гүйцэтгэх захирал О.Амартүвшин:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулж, одоог хүртэл хэлэлцсэн асуудлыг хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалагт танилцуулсан.

Компанид хувьцаагаа эргүүлэн зарах хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн зарах шаардах эрх үүснэ. Иймд энэ асуудлуудыг мөн тусгасан. Хурлын бүртгэлийн өдрөөс өмнөх хувьцааны 6 сарын дундаж ханш 385 төгрөг байна. Иймд шаардах эрхийн хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ энэ ханшаар тогтоно.

Хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалаг:

Том хувьцаа эзэмшигч эргүүлж хувьцаагаа зарсан нь аль компани вэ? Би Ди Сек компанийн хувьцааг хэзээ худалдаж авсан юм бэ?

Гүйцэтгэх захирал О.Амартүвшин:

Би Ди Сек-ийн хувьцааг 2020 онд нэгж хувьцааг нь 300 төгрөгөөр тогтоосон ханшаар худалдаж авсан. Мөн шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдээс хувьцаа худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулсан.

Өөр асуулт байна уу, дараагийн асуудал руугаа орох уу?

Одоогийн байдлаар компанид 4.4 сая халаасны хувьцаа байгаа. Энэ хувьцаа саналын эрхгүй хувьцааг эргэлтээс хасах саналтай байгаа. Энэ асуудал дээр хувьцаа эзэмшигчдийн зүгээс мөн саналын хуудсан дээр өөрийн саналыг өгөөрэй.

Өөрийн өмчөөс худалдан борлуулах дээр гурван ширхэг үл хөдлөх хөрөнгө болон охин компанийн газрын асуудал орсон. Гурван үл хөдлөх хөрөнгөөс Алтай хотхоны 2 орон сууцны байр нь бартераар авсан үнэндээ зарагдахаар байна. Харин 3-4 хороололд бартераар авсан үйлчилгээний зориулалттай угсармалын нэг байр нь уг үнээ барихааргүй буюу 10-20% бартерт авсан үнэнээсээ доогуур зарагдахаар байна. Бартераар байр авах болсон шалтгаан нь хөрөнгө борлуулах явцад бэлэн мөнгөөр худалдаж авах тал олдоогүй, бэлэн мөнгөөр борлуулахаар гэрээ хэлцлийн ярианы

түвшинд хэлцэл хийж байсан гадны компаниуд цар тахлын нөхцөл байдлаас үүдэн сонирхохоо больсон.

Наймдугаар зүйл нь их хэмжээний хэлцэл буюу өмнө тайлбарласан 2009 оноос хойш сунгагдаж ирсэн гэрээний сунгалтын тухай юм. Нөгөө гэрээ нь Вистекс Инвестмэнт ХХК-тай өмнөх удирдлагын үед байгуулсан 1,2 тэрбумын хөрөнгө оруулалтын гэрээ байна. Хоёр дахь гэрээг тухайн үед үйл ажиллагаагаа гадны зах зээл рүү тэлэх чиглэлээр хийж байсан боловч одоогийн байдлаар тухайн компани нь зогсонги мөн тухайн компанийн зах зээлээ тэлэхээр зорьж байсан Мьянмар улсын хувьд ч нөхцөл байдал хүндхэн байна. Эдгээр танилцуулсан зүйлүүдэд асуулт байна уу?

Хурлын дарга Д. Батсайхан

Дараагийн асуудлыг танилцуулах уу

Компанийн захирал О.Амартүвшин:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нэг гишүүн АНУ-д гацсан, нөгөө гишүүн нь гэр бүлийн шалтгаанаар цаашид оролцох боломжгүй байгаа тул гишүүнээс чөлөөлж өгнө үү гэдэг хүсэлтээ аль аль нь тавьсан. Шинэ хоёр гишүүний анкет мэдээллийг танилцуулья.

Дараагийн асуудал 2021 онд бидний голлох үйл ажиллагаа хувьцаа эргүүлэн худалдаж авах, үүнийг санхүүжүүлэх эх үүсвэр олох, компанийн хэлбэр өөрчлөн зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа байхаар байна. Мөн энэ онд татварын зардал 699 сая төгрөгийн зардал гаргахаар байгаа бөгөөд үүнээс 300 сая нь татварын зардал бусад зардал тогтмол гардаг үйл ажиллагааны зардал байна. Компанид үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалан ноогдол ашиг хувиарилах боломжгүй гэдэг шийдвэр гарсан.

Хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалаг:

Бусад асуудалд өгөх санал бий юу? Компанийг өөрчлөн зохион байгуулах дээр сонгосон хэдэн хувьцаа эзэмшигч байна вэ?

Компанийн захирал О.Амартүвшин:

Асуудал хэлэлцэгдээгүй тул өгөх шаардлагагүй. Өөрчлөн зохион байгуулахыг дэмжих эсэхийг хэлж мэдэхгүй байна, санал хураалтын дараа тодорхой болно.

Хувьцаа эзэмшигч Маркус Сеиблэр

Компанийг өөрчлөн байгуулах асуудалд зөвшөөрч байгаа бол саналын хуудсын эхний баганыг бөглөх нь зөв үү.

Компанийн захирал О.Амартүвшин:

Тиймээ, зөв ойлгож байна. Өөр асуулт байна уу

Хурлын дарга Д. Батсайхан

Хэрэв дууссан бол санал хураалтаа явуулах уу?

Хуралд оролцогчид:

Зөвшөөрч байна.

Тооллогын комиссийн дарга:

Санал хураалт явагдаж дууссан байна. Нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс:

1. Компанийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, 91%-ийн саналтай дэмжсэн.
2. Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт батлах, 91%-ийн саналтай дэмжсэн.
3. Компанийн хэлбэр өөрчлөх буюу ХХК болгох асуудлыг хэлэлцэх, 52%-ийн саналтай дэмжсэн.
4. Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай, 91%-ийн саналтай дэмжсэн.
5. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай, 91%-ийн саналтай дэмжсэн.
6. Халаасны хувьцааг бичилтээс хасах тухай, 91%-ийн саналтай дэмжсэн.
7. Хөрөнгө худалдан борлуулах тухай, 91%-ийн саналтай дэмжсэн.
8. Их хэмжээний хэлцэлийг хэлэлцэх тухай /Морьт Импекс ХХК-тай хийсэн гэрээний сунгалт болон хөрөнгө оруулалтын гэрээний сунгалт/, 91%-ийн саналтай дэмжсэн.
9. ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, шинээр сонгох, ТУЗ-ийн 2021-2022 оны цалингийн төсвийг 91%-ийн саналтай дэмжсэн.
10. 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсөв, 91%-ийн саналтай дэмжсэн.
11. Ногдол ашиг хувиарлахгүй тухай шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоол танилцуулах, 91%-ийн саналтай дэмжсэн.

11 асуудал батлагдсан ба бусад гэсэн зүйл дээр асуудал хэлэлцсэнгүй.

Хурлын дарга Д. Батсайхан хурлыг хаав.

Хурал: 16 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн: Зохион байгуулах комиссын гишүүн Г. Алтаймаа

Хянасан: Хурлын дарга: Д. Батсайхан

